



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Г

Г

Тэмцээн зохион байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг байгуулагдсаны 90 жилийн ойн хүрээнд Эрүүл мэнд, спортын яамны харьяа байгууллагуудын дунд Эрүүл мэнд, спортын сайдын нэрэмжит 2015 оны аварга шалгаруулах тэмцээний удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Тус тэмцээнийг удирдамжийн дагуу зохион байгуулахыг Улсын нэгдүгээр төв эмнэлэг /Б.Бямбадорж/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Х.Бакытжан/-т үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

080500

Эрүүл Мэнд, Спортын сайдын 2015 оны 04
сарын 16 өдрийн 147 тушаалын хавсралт

**УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ БАЙГУУЛАГДСАНЫ 90 ЖИЛИЙН ОЙН
ХҮРЭЭНД ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД
ЗОХИОГДОХ ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН НЭРЭМЖИТ 2015 ОНЫ АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Тэмцээний зорилго

Эрүүл мэндийн салбарын ажилчдын чөлөөт цагийг зөв, зохистой, үр бүтээлтэй өнгөрүүлж, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд оролцох идэвхийг өрнүүлэх, нөхөрсөг уур амьсгал бүрдүүлэх, салбарын шилдэг тамирчид, багийг шалгаруулахад оршино.

Хоёр. Тэмцээний зорилт


1. Эрүүл мэндийн салбарын ажилчдыг нийтийн биеийн тамирын арга хэмжээнд хамруулах
2. Шинэ залуу боловсон хүчний авьяас чадварыг нээх, хамт олонч сэтгэлгээг төлөвшүүлэх
3. “Заавал хэвшүүлэх 21 дадал”-ын нэгдүгээр заалтыг хэрэгжүүлэх (Идэвхтэй хөдөлгөөн-дасгал)
4. Шилдэг тамирчид, багийг шалгаруулах

Гурав. Хамрагдах хүрээ

ЭМСЯ-ны харьяа байгууллагад үндсэн ажилтанаар ажилладаг (тухайн байгууллагаас нийгмийн даатгал 2015 оны 2 сараас хойш төлөгдсөн байна) эмч, сувилагч, ажилтнууд оролцоно. Цагийн болон гэрээт ажилтнуудыг оролцуулахгүй болохыг анхааруулж байна.

ЭМСЯ-ны харьяа байгууллагууд

1. Эрүүл Мэнд, Спортын Яам
2. Биеийн тамир, спортын хөгжлийн төв
3. Буянт-Ухаа спортын ордон
4. Эрүүл мэндийн хөгжлийн төв
5. Улсын нэгдүгээр төв эмнэлэг



6. Улсын хоёрдугаар төв эмнэлэг
7. Улсын гуравдугаар төв эмнэлэг
8. Халдварт өвчин судлалын үндэсний төв
9. Гэмтэл согог судлалын үндэсний төв
10. Хавдар судлалын үндэсний төв
11. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
12. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
13. Арьсны өвчин судлалын үндэсний төв
14. Зоонозын өвчин судлалын үндэсний төв
15. Геронтологийн үндэсний төв
16. Цус сэлбэлт судлалын үндэсний төв
17. Эмгэг судлалын үндэсний төв
18. Хүүхдийн төв сувилал
19. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
20. ЭМСЯ-ны зөвшөөрөлтэй зарим хувийн хэвшлийн нэгдсэн эмнэлгүүд

Дөрөв. Тэмцээний төрөл, хугацаа, зохион байгуулагдах газар

2015 оны 5 дугаар сар 2-3-нд Буянт-Ухаа спортын ордонд дараах хуваарийн дагуу болно.

| дд | Тэмцээн | Хугацаа | Цаг | Газар |
|----|--------------------|---------------------------|----------------|-----------------------------|
| 1 | Шатар | 2015 оны 05 сарын 2 | 8:00- 22:00 | Буянт-Ухаа спортын ордон |
| 2 | Ширээний теннис | 2015 оны 05 сарын 2 | 8:00- 22:00 | Буянт-Ухаа спортын ордон |
| 3 | Гар бөмбөг | 2015 оны 05 сарын 2, 3 | 8:00- 22:00 | Буянт-Ухаа спортын ордон |
| 4 | Сагсан бөмбөг | 2015 оны 05 сарын 2, 3 | 8:00- 22:00 | Буянт-Ухаа спортын ордон |

Тэмцээний нээлт 2015 оны 05 дугаар сарын 2-нд 14.00 цагт Буянт-Ухаа спортын ордонд болно. Байгууллагууд тэмцээний нээлт, хаалтын арга хэмжээнд өөрийн байгууллагын туг, далбаа, хаягийг авч ирэх бөгөөд хөгжөөн дэмжигчдийг өргөнөөр оролцуулна.

Эрүүл мэндийн байгууллагууд болон нийгмийн зүтгэлтэн, урлаг, спортын одуудын нөхөрсөг тоглолт

Тав. Тэмцээний заавар


- Баг, тамирчид А, В хэсэгт /оролцох баг, тамирчдын тооноос хамаарч хэсэгт хуваана/ сугалаа сугалан хуваагдаж хэсэгтээ тойргоор тоглоно. Хэсгээс хамгийн олон хожилтой 2 баг тамирчин дараагийн шатанд шалгарах ба цаашид олимпийн системээр явагдана.
- Оноо тэнцсэн тохиолдолд (+-) онооны системээр тоолно.
- **Сагсан бөмбөгийн** тэмцээн олон улсын дүрмээр, эрэгтэй 7 минут, эмэгтэй 6 минутаар тоглох ба тэнцсэн тохиолдолд дахин 2 минутаар сунгаж тоглоно. Минутын амралт болон торгуулын шидэлтийн үед цаг зогсоно. Шигшээ 8, 6 тойргийн тоглолтын сүүлийн 1 минут, шигшээ тоглолтын сүүлийн 2 минут цэвэр цагаар явагдана.
- **Гар бөмбөг** олон улсын дүрмээр, эрэгтэй, эмэгтэй 15 оноогоор 3 үе тоглох ба эхэлж 2 үе хожсон баг хожлыг авна.
- **Ширээний теннис** олон улсын дүрмээр, 11 оноогоор 3 үе тоглох ба эхэлж 2 үе хожсон тамирчин хожлыг авна.
- **Шатарын** тэмцээн олон улсын дүрмээр, цагтай явагдах бөгөөд оноолтыг мэргэжлийн шүүгчид хийнэ.
- Тэмцээнд оролцож байгаа тамирчидтай холбоотой маргааныг Нийгмийн даатгалын ерөнхий газрын лавлагаагааг үндэслэн шийдвэрлэнэ.

Зургаа. Багуудад тавигдах шаардлага

1. Тэмцээний төрөл тус бүрт эрэгтэй, эмэгтэй 1, 1 баг, тамирчдыг оролцуулна.
2. Багууд ижил хувцас, хувийн дугаараар жигдэрсэн байна.
3. Нэг баг сагсан бөмбөгийн багт 8, гар бөмбөгийн багт 8 тамирчинтай байна.
4. Тэмцээнд оролцох баг дутуу хүнтэй тоглохгүй ба тамирчдыг 5 минут хүлээж ирээгүй тохиолдолд эсрэг багт хожлыг өгнө.
5. Тэмцээний үеэр согтууруулах ундаа, тамхийг хэрэглэхгүй.
6. Байгууллагын тамирчид болон хөгжөөн дэмжигчдийн хувийн сахилга батыг чандлан сахина.
7. Шүүгчидтэй зүй зохисгүй харьцаа гаргасан тохиолдолд тэмцээн зохион байгуулагчид болон шүүгчдийн шийдвэрээр тамирчныг тухайн тоглолтоос хасч, нэг тоглолт тоглох эрхийг хасах ба багийг 30000 төгрөгөөр торгож, дараагийн тоглолтонд оролцуулна.

Долоо. Тэмцээний санхүүжилт

1. Байгууллага тус бүр мандатын хураамж 400 000 төгрөгийг техникийн зөвлөгөөн дээр бэлнээр төлнө. Техникийн зөвлөгөөн дээр бооцооны мөнгө өгөөгүй бол тэмцээний сугалаанд оролцуулахгүй болно.
2. Баг бүр тэмцээний зохион байгуулалтанд зориулж мөнгөн дэмжлэг үзүүлж болно.
3. Хамтран ажиллах, ивээн тэтгэгч байгууллагуудын дэмжлэг.



Найм. Шагнал урамшуулал

1. Багийн нийлбэр дүнг бага онооны системээр шалгаруулах бөгөөд оноо тэнцсэн тохиолдолд медалийн чанараар тооцно.

Багийн нийлбэр дүнгээр:

- Нэгдүгээр байр - Шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагнал
- Хоёрдугаар байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал
- Гуравдугаар байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал

2. Тэмцээний төрөл тус бүрд 1, 2, 3-р байр эзлүүлж, өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал гардуулна.
3. Шилдэг тоглогчийг сагсан бөмбөг, гар бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй тус бүр шалгаруулна. Шилдэг тоглогчийг түрүүлсэн багаас, өндөр оноо авсан байх шалгуураар шалгаруулна.
4. Шилдэг хөгжөөн дэмжигч нэг байгууллагыг өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр тус тус шагнаж урамшуулна.